

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: . ГСА-2022/15/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойр хот  
2022 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543156 Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Наранбаяр  
Утас: 70543179 Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Батсайхан  
Утас: 70543179 Цахим хаяг: [batsaikhants@audit.gov.mn](mailto:batsaikhants@audit.gov.mn)

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит”  
ХХК Захирал: Ш.Ичинхорлоо  
Утас: 77270808 Цахим хаяг: [nitsbalance@gmail.com](mailto:nitsbalance@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Запруулсан алдаа.....	15
4.3 Зөвлөмж .....	15

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ГАНБАЯР ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-сүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>99,274,040.61</b>	<b>105,987,600.11</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4,750,000.00</b>	<b>2,229,000.00</b>
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>4,750,000.00</b>	<b>2,229,000.00</b>
3121	<b>Төгрөг</b>	<b>4,750,000.00</b>	<b>2,229,000.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	4,750,000.00	2,229,000.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>94,524,040.61</b>	<b>103,758,600.11</b>
351	<b>Түүхий эд материал</b>	<b>60,407,624.65</b>	<b>65,320,374.15</b>
35110	Тусгай зориулалттай материал	12,292,006.65	10,642,006.65
35130	Эм боох материал	48,115,618.00	54,678,367.50
354	<b>Хангамжийн материал</b>	<b>34,116,415.96</b>	<b>38,438,225.96</b>
35410	Бичиг хэргийн материал	3,016,585.00	5,639,725.00
35420	Аж ахуйн материал	15,564,759.96	17,445,029.96
35430	Сэлбэг хэрэгсэл	2,549,000.00	2,549,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,014,400.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	8,971,671.00	12,804,471.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>103,116,581.65</b>	<b>101,062,691.72</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>103,116,581.65</b>	<b>101,062,691.72</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>91,600,691.49</b>	<b>89,602,691.72</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,364,562.50	5,364,562.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-536,824.47	-804,869.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,000,000.00	50,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-46,646,576.66	-50,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	119,134,039.80	138,710,739.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-90,052,636.86	-102,733,810.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	54,367,431.07	54,367,431.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,054,303.89	-46,989,927.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,025,000.00	14,025,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-2,336,434.35
39216	Дуусаагүй барилга, байгууламж	30,000,000.00	30,000,000.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>11,515,890.16</b>	<b>11,460,000.00</b>
39301	Програм хангамж	863,000.00	863,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-807,109.84	-863,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,460,000.00	11,460,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>202,390,622.26</b>	<b>207,050,291.83</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>202,390,622.26</b>	<b>207,050,291.83</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>202,390,622.26</b>	<b>207,050,291.83</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	226,849,721.93	226,849,721.93
51101	Өмч: - төрийн	226,849,721.93	226,849,721.93
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-24,459,099.67</b>	<b>-19,799,430.10</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-85,025,705.75	-24,459,099.67
51220	Тайлант үеийн үр дүн	60,566,606.08	4,659,669.57
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>202,390,622.26</b>	<b>207,050,291.83</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ГовьСүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>505,905,800.00</b>	<b>477,325,169.50</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>19,272,200.00</b>	<b>11,537,269.50</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>19,272,200.00</b>	<b>11,537,269.50</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,422,200.00	11,537,269.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,469,200.00	5,794,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,918,000.00	5,743,269.50
120009	Бусад орлого	5,850,000.00	0.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>486,633,600.00</b>	<b>465,787,900.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>474,433,600.00</b>	<b>462,909,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	474,433,600.00	462,909,900.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>12,200,000.00</b>	<b>2,878,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,200,000.00	878,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>445,339,193.92</b>	<b>472,665,499.93</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>445,339,193.92</b>	<b>472,665,499.93</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>419,025,802.59</b>	<b>458,249,146.01</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>267,229,149.00</b>	<b>280,786,222.00</b>
210101	Үндсэн цалин	195,689,285.53	201,085,083.00
210102	Нэмэгдэл	63,674,763.52	70,063,539.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,865,099.95	9,637,600.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,373,661.67</b>	<b>37,855,299.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,072,723.80	29,055,255.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,502,440.68	2,333,339.66
210203	ҮОМШ өвчний даатгал	2,288,804.71	1,829,651.70
210204	Ажилгүйдлын даатгал	500,881.96	421,523.40
210205	Эрүүл мэндийн даатгал	5,008,810.52	4,215,529.22
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,051,209.00</b>	<b>37,864,622.00</b>
210301	Гэрэл цахилгаан	1,551,609.00	1,499,039.00
210302	Түлш, халаалт	5,646,200.00	6,109,483.00
210303	Цэвэр, бохир ус	295,400.00	391,100.00
210304	Байрны түрээс	30,558,000.00	29,865,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,146,857.58</b>	<b>30,585,189.00</b>
210401	Бичиг хэрэг	2,905,740.00	3,329,870.00
210402	Тээвэр, шатахуун	12,327,600.00	15,698,500.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,616,021.00	6,602,179.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	1,538,110.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,395,850.00	2,663,020.00
210408	Бараа материал акталсны зардал	4,805,646.58	753,510.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>10,952,100.00</b>	<b>5,261,250.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,602,100.00	4,113,250.00
210502	Хоол, Хүнс	1,350,000.00	1,148,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,522,100.00</b>	<b>19,516,060.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,549,500.00	11,969,160.00
210604	Урсгал засвар	5,972,600.00	7,546,900.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,146,200.00</b>	<b>13,366,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	9,146,200.00	13,366,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,300,550.00</b>	<b>7,581,214.00</b>

ГовьСүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,094,800.00	6,755,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	140,200.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,590.00	122,754.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	748,000.00	198,000.00
210807	Газрын төлбөр	11,460.00	11,460.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	688,500.00	0.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,303,975.34</b>	<b>25,433,289.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.00	3,300,000.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	53,500.00	502,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	19,150,475.34	21,630,589.93
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,313,391.33</b>	<b>14,416,353.92</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,250,000.00</b>	<b>4,050,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,250,000.00	4,050,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>14,063,391.33</b>	<b>10,366,353.92</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,063,391.33	10,366,353.92
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>60,566,606.08</b>	<b>4,659,669.57</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>60,566,606.08</b>	<b>4,659,669.57</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	226,849,721.93	0.00	-24,459,099.67	202,390,622.26
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,849,721.93	0.00	-24,459,099.67	202,390,622.26
8	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	4,659,669.57	4,659,669.57
9	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	226,849,721.93	0.00	-19,799,430.10	207,050,291.83

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ГовьСүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>496,987,800.00</b>	<b>471,581,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,354,200.00</b>	<b>5,794,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>10,354,200.00</b>	<b>5,794,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,504,200.00	5,794,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,469,200.00	5,794,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	0.00
120009	Бусад орлого	5,850,000.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>486,633,600.00</b>	<b>465,787,900.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	474,433,600.00	462,909,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	474,433,600.00	462,909,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>12,200,000.00</b>	<b>2,878,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,200,000.00	878,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>475,237,800.00</b>	<b>456,896,200.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>475,237,800.00</b>	<b>456,896,200.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>448,924,408.67</b>	<b>442,479,846.08</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>267,229,149.00</b>	<b>280,786,222.00</b>
210101	Үндсэн цалин	195,689,285.53	201,085,083.00
210102	Нэмэгдэл	63,674,763.52	70,063,539.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	7,865,099.95	9,637,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,373,661.67</b>	<b>37,855,299.08</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,072,723.80	29,055,255.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,502,440.68	2,333,339.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,288,804.71	1,829,651.70
210204	Ажилгүйдлийн даатгал	500,881.96	421,523.40
210205	Эрүүл мэндийн даатгал	5,008,810.52	4,215,529.22
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,051,209.00</b>	<b>38,557,622.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,551,609.00	1,584,739.00
210302	Түлш, халаалт	5,646,200.00	6,109,483.00
210303	Цэвэр, бохир ус	295,400.00	305,400.00
210304	Байрны түрээс	30,558,000.00	30,558,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,511,321.00</b>	<b>27,076,389.00</b>
210401	Бичиг хэрэг	4,439,900.00	5,324,450.00
210402	Тээвэр, шатахуун	15,684,400.00	11,684,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,791,021.00	5,900,329.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	1,538,110.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,629,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>17,481,118.00</b>	<b>12,261,300.00</b>

ГовьСүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,131,118.00	11,113,300.00
210502	Хоол, хүнс	1,350,000.00	1,148,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>49,020,200.00</b>	<b>19,858,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,292,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	42,950,600.00	10,999,200.00
210604	Урсгал засвар	6,069,600.00	7,566,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,146,200.00</b>	<b>13,366,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	9,146,200.00	13,366,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,511,550.00</b>	<b>8,916,214.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,198,300.00	6,755,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	140,200.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,590.00	122,754.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	924,000.00	913,000.00
210807	Газрын төлбөр	11,460.00	11,460.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	620,000.00	620,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,600,000.00</b>	<b>3,802,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.00	3,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	502,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,313,391.33</b>	<b>14,416,353.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,250,000.00</b>	<b>4,050,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,250,000.00	4,050,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>14,063,391.33</b>	<b>10,366,353.92</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,063,391.33	10,366,353.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>21,750,000.00</b>	<b>14,685,700.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>17,000,000.00</b>	<b>17,206,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>17,000,000.00</b>	<b>17,206,700.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	17,000,000.00	17,206,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,000,000.00	17,206,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-17,000,000.00</b>	<b>-17,206,700.00</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	0.00	0.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>4,750,000.00</b>	<b>-2,521,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>4,750,000.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,750,000.00</b>	<b>2,229,000.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
-----------------------	------------	-----------	-------	------

ГовьСүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>4,750,000.00</b>	<b>-4,750,000.00</b>	<b>0.0</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>462,909,900.00</b>	<b>460,436,546.08</b>	<b>2,473,353.92</b>	<b>99.4</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>462,909,900.00</b>	<b>460,436,546.08</b>	<b>2,473,353.92</b>	<b>99.4</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>460,859,900.00</b>	<b>456,386,546.08</b>	<b>4,473,353.92</b>	<b>99.0</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>280,409,200.00</b>	<b>280,786,222.00</b>	<b>-377,022.00</b>	<b>100.1</b>
Үндсэн цалин	218,697,500.00	201,085,083.00	17,612,417.00	91.9
Нэмэгдэл	52,878,700.00	70,063,539.00	17,184,839.00	132.5
Унаа хоолны Хөнгөлөлт	8,833,000.00	9,637,600.00	-804,600.00	109.1
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,855,300.00</b>	<b>37,855,299.08</b>	<b>0.92</b>	<b>100.0</b>
Тэтгэврийн даатгал	26,638,900.00	29,055,255.10	-2,416,355.10	109.0
Тэтгэмжийн даатгал	2,804,100.00	2,333,339.66	470,760.34	83.2
ҮОМШӨ-ний даатгал	2,243,300.00	1,829,651.70	413,648.30	81.6
Ажилгүйдлийн даатгал	560,800.00	421,523.40	139,276.60	75.6
Эрүүл мэндийн даатгал	5,608,200.00	4,215,529.22	1,392,670.78	75.1
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>42,776,900.00</b>	<b>38,557,622.00</b>	<b>4,219,278.00</b>	<b>90.1</b>
Гэрэл, цахилгаан	1,896,100.00	1,584,739.00	311,361.00	83.5
Түлш, халаалт	7,046,200.00	6,109,483.00	936,717.00	86.7
Цэвэр, бохир ус	506,400.00	305,400.00	201,000.00	60.3
Байрны түрээс	33,328,200.00	30,558,000.00	2,770,200.00	91.6
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,771,000.00</b>	<b>27,076,389.00</b>	<b>-305,389.00</b>	<b>101.1</b>
Бичиг хэрэг	4,439,900.00	5,324,450.00	-884,550.00	119.9
Тээвэр, шатахуун	11,184,400.00	11,684,100.00	-499,700.00	104.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,791,900.00	5,900,329.00	891,571.00	86.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,725,400.00	1,538,110.00	187,290.00	89.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,629,400.00	2,629,400.00	0.00	100.0
<b>Нормативт зардал</b>	<b>12,481,300.00</b>	<b>12,261,300.00</b>	<b>220,000.00</b>	<b>98.2</b>
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,131,300.00	11,113,300.00	18,000.00	99.8
Хоол, хүнс	1,350,000.00	1,148,000.00	202,000.00	85.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>37,069,600.00</b>	<b>37,064,800.00</b>	<b>4,800.00</b>	<b>99.9</b>
Багаж, техник, хэрэгсэл	18,500,000.00	18,499,200.00	800.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,000,000.00	10,999,200.00	800.00	99.9
Урсгал засвар	7,569,600.00	7,566,400.00	3,200.00	99.9
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13,552,100.00</b>	<b>13,366,000.00</b>	<b>186,100.00</b>	<b>98.6</b>
Дотоод албан томилолт	13,552,100.00	13,366,000.00	186,100.00	98.6
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,441,800.00</b>	<b>8,916,214.00</b>	<b>525,586.00</b>	<b>94.4</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,204,300.00	6,755,000.00	449,300.00	93.7
Даатгалын үйлчилгээ	450,000.00	450,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	180,000.00	122,754.00	57,246.00	68.2

ГовьСүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	932,000.00	913,000.00	19,000.00	97.9
Газрын төлбөр	11,500.00	11,460.00	40.00	99.6
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	620,000.00	620,000.00	0.00	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>502,700.00</b>	<b>502,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	502,700.00	502,700.00	0.00	100.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,050,000.00</b>	<b>4,050,000.00</b>	<b>-2,000,000.00</b>	<b>197.5</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,050,000.00</b>	<b>4,050,000.00</b>	<b>-2,000,000.00</b>	<b>197.5</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,050,000.00	4,050,000.00	-2,000,000.00	197.5
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>462,909,900.00</b>	<b>457,558,546.08</b>	<b>5,351,353.92</b>	<b>98.8</b>
Улсын төсвөөс санхүүжих	462,909,900.00	457,558,546.08	5,351,353.92	98.0
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.00</b>	<b>5,794,000.00</b>	<b>-5,794,000.00</b>	<b>0.0</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,794,000.00	-5,794,000.00	0.0
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.0</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>2,229,000.00</b>	<b>-2,229,000.00</b>	<b>0.0</b>
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23.00</b>	<b>23.00</b>		
Удирдах ажилтан	1.00	1.00		
Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00		
Үйлчлэх ажилтан	6.00	6.00		

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
А	В	Г
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>5,756,000.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>2,878,000.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>878,000.00</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		378,000.00
Унаа хоолны Хөнгөлөлт		378,000.00
Хангамж, бараа материалын зардал		500,000.00
Тээвэр, шатахуун		500,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>2,000,000.00</b>
Бусад урсгал шилжүүлэг		2,000,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,000,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>2,878,000.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>2,878,000.00</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		878,000.00

НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)

-2,878,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, цахим төлбөрийн баримтын системийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс Баланс аудит” ХХК-ийн аудитор Н.Батбаяр, ахлах аудитор Ц.Энхтуяа нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг төрийн аудитын байгууллагын аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс Баланс Аудит” ХХК-д хянуулахаар 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 05 дугаар албан бичгээр **хуульд заасан хугацаанд** ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газар үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Нутаг дэвсгэрт төрийн өмнөөс мэргэжлийн хяналт тавьж хуулийн сахин мөрдөлтийг нэмэгдүүлж иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх баталгаа, хүний болон нийгмийн тогтвортой хөгжлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилтоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах зорилтуудбг дэвшүүлсэн байна. Үүнд.

- Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх;
- Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээх, байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах замаар хүрээлэн орчны аюулгүй байдлыг хангуулах, ашиглалтын нөөцийг бий болгоно;
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах;
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”; /2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоол: “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаал “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх баталсан төсвийн нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 3 дугаар улирлын байдлаарх баталсан төсвийн нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 472,665.95 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,726.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,308.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,659.7 мянган төгрөгөөр өссөн байна.

**Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна**

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,750.0	2,229.0	(2,527.0)
Бараа материал	94,524.0	103,758.6	9,234.6
Үндсэн хөрөнгө	103,116.6	101,062.7	(2,053.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>202,390.6</b>	<b>207,050.3</b>	<b>4,659.7</b>
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	202,390.6	207,050.3	4,659.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>202,390.6</b>	<b>207,050.3</b>	<b>4,659.7</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,527.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн зарцуулалттай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 103,758.6 мянган төгрөг болж 9,234.6 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын тайлант оны өөрчлөлтөөс шалтгаалсан байна. Тухайлбал, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 47,831.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, 3,373.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан бол 41,216.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй, 753.5 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 101,062.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,053.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 207,050.3 мянган төгрөг болж 4,659.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого 477,325.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 28,580.6 мянган төгрөгөөр буурсан нь төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 7,734.9 мянга, улсын төсвийн санхүүжилт 11,523.7 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 9,322.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Үйл ажиллагааны нийт зардал 472,665.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 27,326.3 мянган төгрөгөөр буурсан нь дараах зардлын дансдын өөрчлөлтөөс шалтгаалсан байна. Үүнд: Цалин, НДШ-ийн зардал 18,038.7 мянга, хангамж бараа материалын зардал 2,438.3 мянга, эд хогшил урсгал засварын зардал 10,994.0 мянга, томилолтын зардал 4,219.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 4,280.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 5,129.3 мянган төгрөгөөр тус тус өмнөх оны үзүүлэлтээс буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,262,948.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөл 800,038.1 мянган төгрөгөөр буурч, 462,909.9 мянган төгрөгөөр батлагдсан байна. Төсвийн 2021 оны тодотголоор улсын төсвийн санхүүжилтийг 10,004.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 452,905.6 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 зориулалт, арга хэмжээг санхүүжүүлэхээр 462,909.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн 462,909.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, байгууллагын урсгал үйл ажиллагаанд 457,558.5 мянган төгрөгийг зарцуулж, баталсан төсөвт зардлыг 5,351.4 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар хэмнэсэн байна. Төсвийн хэмнэлт нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,219.3 мянга, нормативт зардал болон бусад бараа үйлчилгээний зардал 1,132.1 мянган төгрөгөөр тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
	Код	Нэр			Зөрүү	хувь
1	70417	Мэргэжлийн хяналт	462,909.9	457,558.5	5,351.4	98.8
2	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	460.709.9	455.803.5	4,906.4	98.9
3	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,000.0	875.0	125.0	87.5
4	80227	Лабораторийн итгэмжлэл	1,200.0	880.0	320.0	73.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвийн 2,000.0 мянга, дээд шатны төсөв захирагчийн 878.0 мянга, нийт 2,878.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг бүрдүүлж, ажиллагсдын хоол, унааны хөнгөлөлтөд 378,0 мянга, тээвэр шатахууны зардалд 500.0

мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 2,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант хугацаанд биенес эрхлэгч, иргэн, ААНБ-уудад мэргэжлийн болон хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор 15 чиглэлээр 48 объектын 330 хүнд, 11 чиглэлээр салбарын сургалтыг тус тус зохион байгуулж, шилэн хяналтын цахим мэдээлийн системд бүртгэсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Нутаг дэвсгэрт төрийн өмнөөс мэргэжлийн хяналт тавьж хуулийн сахин мөрдөлтийг нэмэгдүүлж иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, чанартай бүтээгдхүүн үйлчилгээ хэрэглэх баталгаа, хүний болон нийгмийн тогтвортой хөгжлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ” зорилтын хүрээнд 3 хөтөлбөр, 81 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл нь 98.3 хувийн биелэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т: “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” зохицуулалттай байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### **3.9.2 Татварын ерөнхий хуулийн хүрээнд**

Тайлант оны зарим худалдан авалтын 8,772.7 мянган төгрөгийн төлбөрийг цахим төлбөрийн баримтын системд шивүүлээгүй, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаагүй байна

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн цахим төлбөрийн баримтын системийн мэдээлэл нь Татварын ерөнхий хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна .

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2 төлбөрийн акт болон өгсөн 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллажээ.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх, бараа материалын нөөц 103,758,6 мянган төгрөгт хүрч, их хэмжээгээр нөөцлөгдсөн шалтгаан, үр дагавар гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 12,238.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,987.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналтай холбоотой алдааг залруулж, 9,251.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нийт 2,987.1 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын алдааг аудитын явцад залруулсан.

### **4.2 Төлбөрийн акт байхгүй**

### **4.3 Албан шаардлага байхгүй**

### **4.4 Зөвлөмж**

## **1. Санхүүгийн бүртгэл тайлагналтай холбоотой асуудал**

### **1.1 Илрүүлэлт:**

Санхүүгийн тодруулга тайланг бэлтгэж, тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д: "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу цаг хугацаанд үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

### **1.2 Өгсөн зөвлөмж:**

Санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж байх.

## **2. Санхүүгийн бүртгэл тайлагналтай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Тайлант онд олгосон цалингийн дүнг нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн цалингийн дүнгээс 479.1 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т: "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" нийцэхгүй байна.

### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж байх.

## **3. Цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал**

### 3.1 Илрүүлэлт:

Цахим төлбөрийн системд 8,772.7 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шивэгдээгүй, 459.0 мянган төгрөгийн цахим төлбөрийн баримт илүү шивэгдснийг хянаж, залруулаагүй **нь** Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь заалтыг зөрчсөн байна.

### 3.2 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын ажил гүйлгээний цахим төлбөрийн баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системийн шивэлтэд хянаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар</b>											
1	Санхүүгийн тодруулга тайланг бэлтгэж, тайлагнаагүй	1	0.0								
2	Нийт 2,987.1 мянган төгрөгийн ажи1 гүйлгээг буруу бүртгэж, тайлагнасан	1	2987.1	1	2,987.1						
3	Цалингийн дүнг НДШ тайлан дахь цалингийн дүнгээс 479.1 мян.төг-өөр зөрүүтэй илэрхийлсэн	1	479.1							1	479.1
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар хийсэн нийцлийн аудитын тайлангаар</b>											
4	Цахим төлбөрийн системд 8,772.7 мянган төгрөгийг шивүүлээгүй	1	8,772.7							1	8,772.7
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>12,238.9</b>	<b>1</b>	<b>2,987.1</b>					<b>4</b>	<b>9,251.8</b>